

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:*** 1-12

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*** 13-28

---

***1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*** 13-23

***2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/*** 23-26

***3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай/*** 26-28

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаатар;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ж.Баярмаа, Г.Уянгахишиг,  
Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Л.Гантөмөр, О.Цогтгээрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын дарааллын дөрөвдүгээр асуудал болох “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулж байгааг мэдэгдэв./14:09/

**Нэг.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын Дэд дарга Б.Батцэцэг, Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, мөн захиргааны зөвлөх Б.Энхсайхан, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын

хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

**1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаар:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн боловсруулсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус батална.

7.3.Засгийн газар хотод хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн жагсаалтыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батална.

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр, барилгажилтын төслийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хотын Зөвлөл тус тус батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 7

Бүгд: 13

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2. Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн боловсруулсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус батална.

7.3.Засгийн газар хотод хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн жагсаалтыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батална.

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр, барилгажилтын төслийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хотын Зөвлөл тус тус батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.2 дахь хэсэг болгох:

“17.2.Энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвслээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 8  
Бүгд: 13  
38.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4

Бүгд: 13  
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний өмнө “иргэн,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.5.3 дахь заалтын “өмчийн” болон” гэснийг, мөн заалтын “удирдлагыг нь томилох, чөлөөлөх,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал

хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5 дахь хэсгийн “эзэмших” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны



хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дахь заалтыг хасаж, 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуультай нийцүүлэх чиглэлээр Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**““Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Хот байгуулах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 9  
Бүгд: 13  
30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн **О.Номинчимэгийн** “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 8  
Бүгд: 13  
38.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 10  
Бүгд: 13  
23.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 7  
Бүгд: 13  
46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2. “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 5. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Хот

байгуулах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл** /“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5

Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай/**

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ, тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 09 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
14 цаг 07 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Баярмагнай Баярбаатар гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл, “Улсын Их Хурал 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай”.

4.Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” гэж .

Хэлэлцэх асуудалтай. 4 дүгээр асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ ажлын хэсэг байгуулах ёстой тээ? Тэгэхээр 2040 анхны хэлэлцүүлэг, хэлэлцэх эсэх нь хэлэлцэгдээгүй тул энэ 4 дэх асуудлуудыг хойшлуулъя . Ингээд 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**1. Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Танилцуулгыг эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх тухай танилцуулгыг ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүн танилцуулна. Ажлын хэсэг. Ажлын хэсгийг оруулъя. Дэд ажлын хэсэг.

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны дарга болоод гишүүдэд бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр энэ Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хэлэлцээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа.

Ингээд Их Хурлын даргын 1 сарын 2-ны өдрийн 1 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг одоо бас энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу төслийн 7 дугаар зүйлийн 7.28, 7.38, 7.4 дэх хэсэг болон 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөн найруулах саналыг бэлтгэж, 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.6 дахь заалтыг төслийн зохицуулалтаар нь хэвээр үлдээх санал бэлтгэсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.5.13, 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5 дахь хэсэг, түүнчлэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан нийт 4 саналын томъёолол бэлтгэсэн байгаа.

Ингээд хууль баталсантай холбогдуулан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд зарим нэмэлт оруулах шаардлагатай тул эдгээр болон холбогдох бусад Хуульд өөрчлөх тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан заалт, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгах саналаа ингээд ажлын хэсгийн дэд хэсэг болон Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөхүүдийн хамтаар ингээд бэлтгэсэн байгаа.

Ингээд Шинэ Хархорин хотын нэр өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор болон хууль тогтоомжийн төслийг нийцлийг хангах хүрээнд 5 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Ингээд та бүхэнд бас энэ саналуудыг танилцуулж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Баярбаатар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн.

**Б.Баярбаатар:** Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Өнгөрсөн Байнгын хорооны хуралдаан дээр бас зарчмын зөрүүтэй 60-аад санал хураалгасан. Тэр санал дээр 2 саналыг Байнгын хороо дэмжиж орсон юм. Нэг нь бол энэ газар эзэмшүүлэх, ашиглах гэсэн нөхцөлөөр тусгая гэдэг байдлаар Байнгын хороо дэмжсэн.

Нөгөөх нь бол харьяа газар гэдэг үг хэвээрээ явуулъя гэж, алба биш харьяа газар гэдгээр нь хэвээрээ явуулъя гээд. Чуулганы хуралдаан дээр бол ороод тухайн санал бол дэмжигдээгүй унасан гэж ойлгож болно.

Тэгэхдээ өнөөдөр би протоколд энэ асуудлыг одоо үлдээх зорилгоор үг хэлж байгаа юм. Жишээлбэл, энэ би ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүнтэй бас түрүүн энэ талаар нэлээн зөвшилцөөд одоо энэ 10.5 дээр Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ барилгажилтын төслийн дагуу Засгийн газрын шийдвэрээр улс хотын төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг чөлөөлөх журмыг Засгийн газар батална гэсэн. Энэ дээр энэ ерөнхий төлөвлөгөө гэдэг үг орчихсон байгаа. Ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батлах юм байна. Тийм ээ?

Тэгэхээр энэ дээр одоо яг тэр эзэмшүүлэх гэдэг агуулгаараа бас дараа дараадаа тэр газрыг эзэмшүүлж байж хөрөнгө оруулалт татна шүү дээ бид нар. Ашиглах дээр одоо хөрөнгө оруулалт орж ирэх болов уу, үгүй болов уу гэдэг асуудал. Тэгээд сая 2, 3-хан хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Турк Улсад ажилласан айлчлалаар энэ Хархорин хотын хөрөнгө оруулалтын гэрээн дээр бас хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах шиг боллоо.

Тэгэхээр эдгээр зүйлүүдээ цааш нь бид нар амь оруулж явуулахын тулд энэ эрх зүйн орчин аль болох тийм нээлттэй, саадгүй байх л ийм зохицуулалт байх ёстой гэж үзэж байгаа юм. Байх ёстой гэж үзэж байгаа юм. Дээр нь мэдээж энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульдаа нийцээд явах нь зүйтэй. Цаашлаад бусад одоо Газрын хуулиар бол ер нь олон асуудлууд зохицуулагдаж байгаа шүү дээ. Тэр болгон өнөөдөр аймгийн Засаг дарга нар жишээлбэл газар олгох эрхтэй өнөөдөр байгаа юу гэвэл яг эрх зүйн орчин бол байхгүй шүү дээ. Энэ чинь Газрын хуулиараа тусгай дуудлага худалдаа иймэрхүү зүйлээр явж байгаа.

Тэгээд энэ Хархорин хотын газар ч гэсэн яг энэ хуулийн зохицуулалтад ороод уул нь явах ёстой учраас тэр эрх зүйн орчныг нь аль болох нээж өгөх нь зөв болов уу гэсэн ийм санал байгаа.

Дээр нь тэр харьяа газар гэдэг зүйлийг одоо бид нар уул нь дахин найруулаад дэргэдэх гэдэг үгээр уул нь орлуулаад явсан бол илүү өнөөдрийн яг мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалттай их нийцээд явах байсан юм болов уу гэдэг ийм санал байна. Тэгээд энэ саналаа протоколд үлдье. Тэмүүлэн даргаас одоо яг тэр саяын эзэмшүүлэх гэдэг зүйлийг хот төлөвлөлтийг Засгийн газраас батлах үед одоо бас орох уу гэдэг асуултыг асууя.



**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүлэн гишүүний микрофоныг нээе.

**Г.Тэмүүлэн:** Баярбаатар гишүүний бас асуултад хариулъя.

Тэгээд яах вэ, бид нарын хувьд гол энэ Хархорин хотын төлөвлөлт болоод бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд бас зохицуулж байгаа гол үндсэн харилцаа маань л төлөвлөлттэй холбоотой асуудлууд байгаад байгаа. Дараагийн шатын хот байгуулалттай холбоотой газар эзэмших, ашиглахтай холбоотой харилцаанууд бол тодорхой бусад хууль тогтоомжуудынхаа хүрээнд зохицуулагдаад явах боломжтой гэж үзэж байгаа. Ер нь энд орж ирснээр бид нар бас саяын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө эд нарыг Улсын Их Хурлаар оруулж ирж батлуулах нь зарчмын хувьд зөв байх гэж харж байгааг.

Тэгэхээр нэг талдаа ойрын хугацаанд манай Хархорин хотын хөгжлийг дэмжих, бүтээн байгуулалтыг зохион байгуулах энэ газрынхан маань бол энэ ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлалаа бол эцэслэхээд ингээд энийгээ Улсын Их Хурлаар орж ирж танилцуулаад, тэр хүрээндээ тэрний дараа энэ газартай холбоотой асуудлуудаа болон хуулийн зохицуулалтуудаа шаардлагатай бол нэмж оруулж ирээд зохицуулалтуудыг хийгээд явах боломж байгаа байх гэж бас харж байгаа.

Ер нь бол бид нарын гол ажлын хэсэг дээр болоод Их Хурал дээр ч гэсэн бас яригдаад байгаа асуудал, газар эзэмшүүлэх харилцаатай холбоотойгоор ямар нэг байдлаар Улаанбаатарын төлөвлөлтгүй энэ зохицуулалтууд бас үүсэх эрсдэл байна. Тэгэхээр энийг бол нэг талдаа бас 7 хэмжиж 1 огтлох ёстой гэдэг зарчмын хүрээнд энэ асуудалд нухацтай бөгөөд болгоомжтой хандах ёстой л гэсэн ийм суурь зарчмын байр сууриас бас хандаад байгаа. Энийг ч одоо бид нар бас үгүйсгэх аргагүй Улсын Их Хурал гишүүдийн энэ гаргаж байгаа саналд бол нэг талдаа хүндэтгэлтэй хандаад явах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тэгэхээр бид бүхний хувьд дараа дараагийн бас Монголчуудын амбиц байгаа, нийслэл хот болох боломжтой энэ газар нутаг дээр бол газар эзэмших харилцаан дээр илүү болгоомжтой хандаж, дараа дараагийн Улсын Их Хурал бас энэ ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал, төлөвлөгөөг баталсны дараагаар зохицуулалтуудыг шаардлагатай тохиолдолд хийгээд явах нь зүйтэй гэсэн ийм байр сууриас хандаад явж байгаа. Бүр онцгой шаардлагатай тохиолдолд одоо Улсын Их Хурал энэ асуудлууд дээр бас онцгойлж хандаад явна гэсэн ийм байр суурьтай байна. Одоо бол нэг талдаа бас Улсын Их Хурлынхаа дэгийн тухай хуулиар эзэмшүүлэх болоод саяын тэр харьяа газартай холбоотой зохицуулалтууд бүгд Улсын Их Хурал дээр саналууд нь дэмжигдээгүй учраас бид нар ямар нэг байдлаар энийг эргэж ярих боломж, бололцоо дэгийнхээ хуулиар байхгүй байгаа л гэдгийг бас хэлэх байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл сайд сая чөлөө аваад явлаа. Алтангэрэл сайдыг ирцээс хасъя.

Ингээд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу?

Байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд санал хураалт байгаа.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хураалгах санал. Энэ чинь

1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2. Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн боловсруулсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус батална.

7.3.Засгийн газар хотод хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн жагсаалтыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батална.

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр, барилгажилтын төслийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хотын Зөвлөл тус тус батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.”

Санал гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт.

Минийх бас болсонгүй ээ. Би санал гаргачихъя. Төхөөрөмж ажилласангүй тул санал хураалтыг дахин явуулъя гэсэн ийм саналыг гаргаж байна. Хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Санал хураалт

Санал хураалтад 13 гишүүнээс 7 гишүүн оролцож, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулъя.

Санал хураалт 13 гишүүнээс 7 гишүүн санал өгч, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.2 дахь хэсэг болгох:

“17.2.Энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт

13 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Зулпхар гишүүнийг дэмжсэнээр оруулъя.

Дараагийн санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу буюу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээс санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул санал хураалтыг дахин явуулна.

1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний өмнө “иргэн,” гэж нэмэх гэдгийг Улсын Их Хурлын Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалгах. Санал хураалт.

Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Байнгын хорооны дарга аа би сая саналаа өгч амжсангүй. Энэ санал хураах төхөөрөмжийнхөө хугацааг нь багасгачихсан юм байна шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Минийх бас болж өгсөнгүй ээ. Тэр улаан гардаг юм нь гараад ирлээ.

Ингээд Шижир гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт.

13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар санал хүчингүй болгоё гэсэн санал дэмжигдлээ.

Санал хүчингүй болсон тул санал хураалтыг дахин явуулъя.

Минийх ч болохгүй байна шүү дээ. Би санал би өөрөө гаргачихъя.

Төхөөрөмж ажилласангүй тул санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн ийм саналыг гаргаж байна. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал хүчингүйд тооцогдлоо.

Ингээд дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар дэмжсэн тул одоо санал хураалтыг явуулъя.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний өмнө “иргэн,” гэж нэмэх. Санал хураалт.

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалт явуулъя. Гуравны хоёроор санал дэмжигдэнэ. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжигдэж, 61.5 хувиар. Айн? Тийм байна гуравны хоёроор.

Минийх бол ерөөсөө бүр болохоо байлаа. Дахиад нэг үзэх үү? Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж, 61,5 хувиар санал хүчингүйд тооцогдлоо.

Энэ Ай Ти дуудах уу, яах вэ? Үзэх үү? Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.4-д заасны дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдсэн тул

2, харин тийм байна.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5.3 дахь заалтын “өмчийн” болон” гэснийг, мөн заалтын “удирдлагыг нь томилох, чөлөөлөх,” гэснийг хасах. Санал хураалт санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гуравны хоёроор л доо. Минийх бас орсонгүй ээ. Тийм болохоор энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн ийм саналыг гаргаж байна.

Ингээд саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдсэн тул санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Ингээд гуравны хоёроор дахиад санал хураалт явуулъя. Санал хураалт.

Номтойбаяр гишүүн.

Номтойбаяр гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал хураалт хүчингүйд тооцогдлоо.

Одоо нэг хариуцлагатайхан шиг санал хураалт өгөх гээд үзье. Санал хураалт. Гуравны хоёроор.

13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар санал дэмжигдсэн тул.

3.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5 дахь хэсгийн “эзэмших” гэснийг тус тус хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт гаргая. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн дараах зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалгах санал. Энэ гуравны хоёроор бас хураагдана. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар санал дэмжигдлээ.

Үүнтэй уялдуулаад.

1.Төслийн 2, 3 дахь заалтыг хасаж, 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуультай нийцүүлэх чиглэлээр Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Зулпхар гишүүн танилцуулах уу?

Зулпхар гишүүн танилцуулна.

Ажлын хэсгээс боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг үндэслэн “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”,

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Ингээд тогтоолын төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд тогтоолын төслүүдийг санал хураалт явуулъя. Эхний санал хураалт.

1. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Дарга саналын төхөөрөмж ажиллахгүй сая санал өгсөн боловч эсрэг гарлаа. Тэгэхээр хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

“Хот байгуулалтын тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Айн? Тэгвэл сая Номинчимэг гишүүний гаргасан горимын саналаар. Горим дэмжигдсэн үү? Саяынх тэгвэл горим дэмжигдэж санал хураалт хүчингүй болсон тул одоо санал хураалт явуулъя. Санал хураалт.

Би дахиад горимын санал гаргая даа. Энэ ерөөсөө болж өгөхгүй байна.

Энэ ер нь өөрчлөлт хийчихсэн юм байна шүү дээ тээ тоног төхөөрөмж? 12 секунд болгосон юм уу? Болохгүй байна.

Ингээд тоног төхөөрөмж болсонгүй тул уг нь бол би бол дэмжиж байгаа. Тоног төхөөрөмж болохгүй байгаа тул санал хураалтыг дахин явуулъя гэсэн

горимын санал гаргаж байна. Тэгээд горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 46.2 хувиар бас санал дэмжигдсэнгүй. Энэ ерөөсөө тоног төхөөрөмж ажиллахгүй байна. Энэ юуныхыг нь л дуулахгүй бол болохгүй байна шүү.

Баярбаатар гишүүн санал гаргая

Баярбаатар гишүүний микрофоныг.

**Б.Баярбаатар:** Горимын санал гаргая . Энэ төхөөрөмж маань санал хураалтын систем маань 15 секундээр тоологдож ажилладаг байсныг тохиргоо шинэчилж хийгээд 12 секунд болгож бууруулсан юм байна. Үүнтэй холбогдуулаад бас зарим нэг гишүүдийн хуруу таних, танигдахгүй гэсэн ийм нөхцөл байдал үүсээд байгаа учраас үлдсэн санал хураалтуудыг илээр буюу гар өргөж санал хураалт явуулах горимын санал оруулж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярбаатар гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гараар санал хураалт явуулъя гэсэн санал гаргаж байна. Тийм болохоор санал хураалт. Баярбаатар гишүүнийхийг. Айн? Энэ ч бас гараар бил үү?

Тэгвэл санал хураалт явуулъя. Саяын гаргасан саналын томъёоллоор дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Энэ чинь 13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж горимын санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо энэ чинь 2 юу байгаа тээ? 2 дахь нь тийм үү?

“Хот байгуулах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт .

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ. Тэмүүлэн гишүүн. Тэмүүлэн гишүүний микрофоныг нээе.

**Г.Тэмүүлэн:** Сая Байнгын хороогоор 5 тогтоолын төсөл маань анхны хэлэлцүүлэг нь дэмжигдсэнтэй холбогдуулаад анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах бас горимын санал гаргаж байна. Энийг дэмжиж өгөөч ээ л гэж хэлэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүлэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Зулпхар гишүүн танилцуулъя.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудал оръё.

14.53 цаг

**“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Тогтоолын танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Засгийн газар 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх албан хаагчдын цалингийн нэмэгдэлд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосонтой холбогдуулан Улсын Их Хурлаас цалингийн хэмжээг тогтоодог Үндсэн хуулийн цэц, Ерөнхий прокурорын газар, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газраас саналаа ирүүлсэн.



Улсын Их Хурал 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч, шүүгч бус гишүүний, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг тус тус өөрчлөн баталсан бөгөөд тогтоолын эцсийн найруулгыг сонсох, ёсчлох үйл ажиллагаа хийгдээгүй тул Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг төсөлд тусгаагүй болно.

Дараагийн 4 дэх өдрийн чуулганаар энэ тогтоолын эцсийн найруулгыг сонссоноор дахин хуралдаж бид нар шийдэх ийм боломж, бололцоо нээгдэж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт энэ хуулийн 45.1-д зааснаас бусад асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид тухайлан заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаарх хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

45.5 дахь хэсэгт Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах саналыг энэ хуулийн 45.2, 45.3, 45.4-д заасан журмын дагуу хэлэлцэнэ гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

“Зарим байгууллагын байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ингээд танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Болормаа гишүүнээр тасаллаа. Болормаа гишүүний микрофоныг нээе.

**Э.Болормаа:** Энэ тогтоолын төсөл дээр болохоор төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн цалингийн хэмжээний мэдээлэл байгаа. Энэ дээр ер нь цаашид бид Их Хурлын харьяа болон Засгийн газрын харьяа байгууллагуудын энэ цалингийн хэмжээн дээр нэгдсэн тийм судалгаа байна уу? Бид нар энэ итгэлцүүрийг бусад байгууллагуудтай нь харьцуулж үзэх нь ер нь хүний нөөцийн бодлогодоо аягүй чухал байгаа.

Яагаад гэвэл нэг байгууллагын цалинг нэмэхээр бусад одоо төстэй мэргэжлийн байгууллагуудаас нь тухайн байгууллага руу хүмүүс шилжих ч юм уу ийм дам нөлөөнүүд их байдаг.

Тэгэхээр яг энэ цалингийн хэмжээг өөрчлөх одоо энэ тогтоолтой холбоотой судалгаа байгаа юу гэж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 2025 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Засгийн газраас оруулж ирсэн шүү дээ. 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож 25 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж дагаж мөрдөх албан тушаалтны цалингийн нэмэгдлийг Засгийн газраас оруулж ирсэн.

Тэгэхээр Засгийн газар тухайн үед мэдээж одоо энэ чинь үндэслэл бүх зүйлүүдээ бол гаргаж ирээд 6 хувиар нэмэгдүүлье гэсэн ийм байдлаар Засгийн газар зохих байгууллагуудаас нь авч судалгаа, шинжилгээг нь хийж байгаад оруулж ирсэн л гэж бодож байгаа.

Гишүүд асуулт асууж дууслаа. Болормаа гишүүн.

**Э.Болормаа:** Тэгэхээр энийг яг тодруулъя. Яагаад гэвэл бид нар одоо ингээд байгууллагын цалинг нь, албан тушаалын сарын хэмжээ ингээд үнийн дүнгээр нь ийм байдлаар яагаад гаргаж байгаа юм бэ? Тэгвэл яг энэ тоог юун дээр үндэслэж гаргаж байгаа юм бэ гэж тэр тооцоо, судалгаа байна уу л гээд байгаа юм.

Тэгэхээр Засгийн газрын тогтоолыг дагаж ирж байгаа юм уу? Яагаад бид Төрийн байгуулалтын байнгын хороо тэгвэл ийм хэмжээний юм хэлэлцээд сууж байгаа юм бэ? Хэрвээ ийм хэмжээний одоо дүн ярих гэж байгаа бол тооцоо, судалгаатай цалингийн асуудалд ер нь хандвал яасан юм бэ гэдэг ийм асуулт оруулж ирж байна.

Тэгэхээр тооцоо судалгаа байгаа юу? Засгийн газар тэгвэл энийг оруулж ирж байгаа Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан бол энэ дээрээ тооцоо судалгаа байна уу? Энэ дам нөлөө ихтэй асуудал учир би энийг хэлээд байгаа юм л даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үгүй ээ энэ чинь улсын төсөвтэй холбоотой асуудал бол Сангийн яам болоод Засгийн газар өөрсдөө тооцоогоо хийгээд оруулаад ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар дахин давхар одоо тооцоолол хийгээд ингээд улсын төсөвтэй. Тухайн үед бид нар улсын төсөв хэлэлцэхэд чинь тэнд чинь ярилцаад ингээд өнгөрсөн асуудал шүү дээ. Тийм тэх.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбоотой, танилцуулгатай холбоотойгоор асуулт санал хэлэх гишүүд байна уу? Болормаа гишүүн. Ингээд тасалъя Болормаа гишүүний микрофоныг нээе.

**Э.Болормаа:** Ингээд сая асуулт дээр тайлбараас ойлгохдоо 25 оны төсвийн тухай хуульд 6 хувийн цалингийн нэмэгдлийг одоо хэрэгжүүлэхийн хүрээнд энэ байгууллагуудыг оруулж ирж байна гэж ойлгож байна.

Цаашдаа бид энийгээ хийхдээ ингээд Төрийн байгуулалтын байнгын хороогоор ингэж байгууллага болгоноор хүмүүсийн цалинг тогтоох нь жоохон бодлогын хувьд учиргүй юм аа, учир дутагдалтай асуудал юм аа гэж. Тэгээд Засгийн газрын хувьд бол цалингийн бодлогоо энэ хөрөөний ир шиг байгаа байдлыг болиулахыг бодлогоор харж үзээч ээ. Их Хурлын харьяа байгууллагуудыг ч гэсэн бид харж үзэх ёстой. Тэрнээс биш өнөөдөр Их Хурлын гишүүд энд хуулиар шахуу, тогтоолоор ингээд тэдэн сая тэдэн зуун төгрөгөөр ингээд хүний цалин тогтоон сууна гэдэг өөрөө би их учир дутагдалтай асуудал юм болов уу. Энэ илүү бодлоготой ханддаг болоосой.

Тэгэхээр энэ дээрээ, тогтоол дээрээ ч гэсэн энийг бас нэмж оруулаад цаашдаа ийм хуулиар эсвэл ингээд Байнгын хороогоор хэлэлцэх шаардлагагүй баймаар байна. Тэр тал дээр шийдэл гаргаач гэдгийг би бас Байнгын хорооныхондоо хэлье гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Улсын Их Хурал төсөв баталчихсан тийм үү? Тэгчхээд хамгийн гол нь тухайлан Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагын тухайн хуульд нь Улсын Их Хурал тогтооно гээд хуульдаа заачихсан байгаа болохоор бид нар энийг нь баталгаажуулж л өгч байна гэж байгаа байхгүй юу.

Түүнээс биш бид нар өөрсдөө тогтоогоод одоо судалгаа гаргаад бид нар тогтоогоод байгаа юм биш. Тэгэхээр энэ бол яг хуульд заасныхаа дагуу бид нар Улсын Их Хурлаар төсөвт баталсан цалингийн хэмжээг нь л баталгаажуулж л өгч байна гэж ойлгож байгаа юм.

Ойлголоо. Ингээд гишүүд санал хэлж дууслаа. Санал хураалт явуулъя.

Санал хураалт явуулъя. Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүнийг танилцуулна.

Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орьё.

15.05 цаг

**“Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

“Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 42 дугаар тогтоолын 2 дахь заалтад Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байнгын, Дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасан.

Ингээд уг заалтын дагуу “Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж байна.

Ингээд тогтоолын төслийг Булгантуяа дарга танилцуулна. Булгантуяа даргын микрофоныг нээе.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2023 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Улсын Их Хурал стратеги, төлөвлөгөөтэй байх, түүнийг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих нь Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эрх зүйн шинэ зохицуулалтыг бий болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөөг баталсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг тодорхойлж, 5 зорилго, бодлого, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх 16 зорилтыг хүрэх үр дүнгийн хамт тодорхойлсон байгаа.

Тогтоолын 2 дахь заалтаар Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байнгын, Дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасан байгаа.

Тогтоолын төсөлд Байнгын, Дэд хороодын саналыг албан ёсоор авч тусгасан. 2025 онд Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 27 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд шалгуур үзүүлэлтийг тоо, чанараар гарган тухайн арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Байнгын хороо байгуулахыг тодорхойллоо.

2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө агуулгын хувьд Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон хяналт шалгалтын ажлын цаглавартай давхцахгүйгээр стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж тус төлөвлөгөөнд тусгагдсан үр дүнд хүрэхэд чиглэгдсэн арга хэмжээг нэн түрүүнд тусгалаа.

Байнгын хороодоос би бичгээр бол 2024 оны 12 дугаар сарын 28-нд санал авсан. Нийт гишүүдэд и-мэйлээр энэ оны 1 сарын 16-нд хүргүүлсэн. Мөн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдэд цахимаар 1 сарын 16-нд та бүгдэд хүргүүлсэн байж байгаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө  
ҮҮ.

Алга байна.

Танилцуулгатай холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

“Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт .

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. “Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 25 оны төлөвлөгөө батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

15.09 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Д.ОТГОНДЭЛГЭР**